



I-III/2022

Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 16



Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 12.1 хувь болж, өмнөх улирлаас 0.2 нэгж хувиар өслөө

Ажиллах хүчний судалгааны 2022 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 1.2 сая нь **ажиллах хүч** байна.

ЗУРАГ 1. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ, 2022 оны 1 дүгээр улиралд, мянган хүнээр



Ажиллах хүчний 1.1 (91.5%) сая нь **ажиллагчид** байна. Ажиллагчид өмнөх оны мөн үеэс 73.6 (7.0%) мянгаар, өмнөх улирлаас 1.3 (0.1%) мянгаар өссөн байна.

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны хүн амын 892.8 (42.0%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Тэдгээрийн 46.5 (5.2%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүч байна.


Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 46.5 (30.0%) мянга нь **боломжит ажиллах хүч**, 104.4 (67.4%) мянга нь **ажилгүй хүн**, 4.0 (2.6%) мянга нь **цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид** байна.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 61.3 (28.4%) мянгаар буурч, өмнөх улирлаас 3.6 (2.4%) мянган хүнээр өссөн байна.

Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 3.2 (3.2%) мянгаар, өмнөх улирлаас 5.0 (5.0%) мянгаар өссөн байна. Ажилгүй хүний тоо өмнөх оны мөн үеэс 35-39 насны бүлэгт 5.8 мянгаар, 40-44 насны бүлэгт 5.3 мянгаар, өмнөх улирлаас 35-39 насны бүлэгт 6.0 мянгаар тус тус өсжээ.

Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 62.3 (57.3%) мянгаар буурч, өмнөх улирлаас 1.4 (3.1%) мянгаар өссөн байна. Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс буурахад 35-49 насны бүлэгт 29.5 мянгаар, 20-29 насны бүлэгт 19.4 мянгаар буурч, өмнөх улирлаас өсөхөд 30-34 насны бүлэгт 2.6 мянгаар, 50-64 насны бүлэгт 4.0 мянгаар өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 2. АЖИЛЛАХ ХҮЧ, АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ, насны бүлгээр, 2022 оны 1 дүгээр улиралд, хүнээр




Нийт ажиллагчдын 31.4 (2.8%) мянга нь сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа /тогтмол хийдэг ажил/ цалин хөлс, орлого олох ажилтай ажиллагчид байгаа нь өмнөх оны мөн үеэс 60.0 (65.6%) мянгаар буурч, өмнөх улирлаас 1.4 (4.7%) мянгаар өсжээ. Харин сүүлийн 7 хоногт ажиллаагүй ажиллагчдын 2.4 (13.6%) мянга нь үүсээд байгаа цар тахалтай холбоотой шалтгаанаар ажиллаагүй байгаа нь өмнөх оны мөн үеэс 56.6 (95.9%) мянгаар, өмнөх улирлаас 2.1 (46.7%) мянгаар тус тус буурчээ.

ХҮСНЭГТ 1. СҮҮЛИЙН 7 ХОНОГТ АЖИЛЛААГҮЙ Ч БУЦАЖ ХИЙХЭЭР ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ЦАЛИН ХӨЛС, ОРЛОГО ОЛОХ АЖИЛТАЙ АЖИЛЛАГЧИД, улирлаар

Хугацаа		Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа ажилтай		Үүнээс цар тахалтай холбоотой	
		мянган хүн	хувь	мянган хүн	хувь
2020	I-III	65.7	5.6	15.7	32.2
	IV-VI	57.1	4.8	19.6	34.3
	VII-IX	56.8	4.8	25.8	45.3
	X-XII	156.4	13.9	124.7	79.8
2021	I-III	91.4	8.7	59	64.6
	IV-VI	114	10.3	85.5	75
	VII-IX	62.4	5.5	17.4	27.9
	X-XII	30	2.7	4.5	14.9
2022	I-III	31.4	2.8	2.4	13.6

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2022 оны 1 дүгээр улиралд, дүнд эзлэх хувиар




Ажиллагчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагчид 26.9 (34.0%) мянгаар, боловсролын салбарынх 12.7 (14.7%) мянгаар өсөж, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарынх 7.0 (31.8%) мянгаар буурсан байна. Харин өмнөх улиралтай харьцуулахад боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагчид 24.5 (30.0%) мянгаар, ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбарынх 22.2 (8.0%) мянгаар өсөж, салбарынх 14.4 (15.9%) мянгаар, барилгын салбарынх 13.8 (17.1%) мянгаар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар, мянган хүнээр

Салбар	2021		2022
	I-III	X-XII	I-III
Дүн	1 054.9	1 127.1	1 128.5
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	303.1	277.8	300.0
Уул уурхай, олборлолт	49.0	56.2	56.0
Боловсруулах үйлдвэрлэл	79.2	81.6	106.1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	17.0	16.8	21.2
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	11.4	5.9	7.1
Барилга	60.5	80.9	67.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	139.2	143.5	135.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	51.1	67.2	60.9
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	34.8	34.5	34.1
Мэдээлэл, холбоо	10.0	19.0	15.6
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	23.6	29.2	20.9
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1.0	2.6	4.3
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	9.5	17.1	12.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	21.7	13.0	14.8
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	76.3	90.4	76.0
Боловсрол	86.3	111.3	99.0
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	45.1	47.1	50.0
Урлаг, үзвэр, тоглоом наадам	8.8	6.3	15.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23.2	24.1	28.8
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2.4	2.6	1.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	1.7	-	2.4

Ажиллагчдын тоо өмнөх улирлаас өсөхөд хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд цалин хөлстэй түр ажиллагч (37.0 мянгаар), цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн ажиллагчид (10.5 мянгаар), гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагч (6.8 мянгаар) тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧИД, 2022 оны 1 дүгээр улиралд, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, өмнөх оны мөн үе болон өмнөх улиралтай харьцуулснаар, мянган хүнээр




Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх дөрвөн үзүүлэлтүүд өмнөх улиралтай харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 0.2 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 0.4 нэгж хувиар, ажилгүй хүн болон цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн түвшин 0.1 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 0.4 нэгж хувиар өссөн байна. Харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 5.0 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 0.3 нэгж хувиар, ажилгүй хүн болон цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн нэгдсэн түвшин 0.5 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 4.8 нэгж хувиар буурсан байна.

ХҮСНЭГТ 3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ, хүйсээр

Үзүүлэлт	Бүгд	2021 I-III		Бүгд	2022 I-III	
		Эрэгтэй	Эмэгтэй		Эрэгтэй	Эмэгтэй
Хөдөлмөрийн дутуу ашиглалт, мянган хүн	216.3	117.4	98.9	154.9	92.2	62.7
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	3.5	2.8	4.0	2.6	1.4
Ажилгүй хүн	101.2	59.9	41.3	104.4	66.8	37.6
Боломжит ажиллах хүч	108.8	54.0	54.8	46.5	22.8	23.7
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, хувь	17.1	17.6	16.6	12.1	13.3	10.7
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.8	9.8	7.6	8.5	10.0	6.7
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, хувь	9.3	10.3	8.1	8.8	10.4	6.9
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, хувь	16.6	17.0	16.1	11.8	12.9	10.5

ЗУРАГ 5. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, 2022 оны 1 дүгээр улиралд, насны бүлгээр




Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан) болон 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) гэсэн насны бүлгээр харуулав. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үндсэн 4 үзүүлэлтүүдэд 15-24 насныхан буюу боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд дийлэнх нь байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин 2022 оны эхний улиралд 58.0 хувь болж, эрэгтэйчүүдийнх 66.5 хувь, эмэгтэйчүүдийнх 50.4 хувь байна. Ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх улирлаас 0.3 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 3.1 нэгж хувиар өссөн байна.

Хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувь буюу **хөдөлмөр эрхлэлтийн түвшин** 53.1 хувь болж, өмнөх улирлаас 0.5 нэгж хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 3.0 нэгж хувиар өссөн байна. Хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийнх 59.8 хувь, эмэгтэйчүүдийнх 47.0 хувь байна.

ЗУРАГ 6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, 2022 оны 1 дүгээр улиралд, насны бүлгээр, хувиар



Ойлголт, тодорхойлолт

Үндэсний Статистикийн Хорооны дарга, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас мөрдөж байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээллийн гол эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгааг шинэ ойлголт тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж байна.



Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ **боломжит ажиллах хүчийг** тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр **өргөтгөсөн ажиллах хүч** илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, **цалин хөлс, орлого олох зорилгоор** бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

Ажил олгогч гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагч гэдэгт ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй. Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа

ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна.

Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилч юм.

Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилч юм.

Гүйцэтгэх гэрээлэгч гэж эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.

Цалин хөлстэй ажиллагч гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрт) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм. Цалинтай ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтаас нь хамаарч 4 ангилна.

Цалин хөлстэй байнгын ажиллагч гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.

Цалин хөлстэй түр ажиллагч гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

a. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

- б. **ажил хийхэд бэлэн** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;
- в. **ажил хайж байгаа** гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- а. **Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч** буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;
- б. **Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн** буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

Тооцох аргачлал

Ажиллах хүч: Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн}$$

Өргөтгөсөн ажиллах хүч: Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Өргөтгөсөн ажиллах хүч} = \text{Ажиллах хүч} + \text{Боломжит ажиллах хүч}$$

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчид}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин:

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

$$\text{ХДАТ 1} = \frac{\text{Ажилгүй хүний тоо}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-2).

$$\text{ХДАТ 2} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{ЦХХББХЭ}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$

Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин: Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-3).

$$\text{ХДАТ 3} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин: Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-4).

$$\text{ХДАТ 4} = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{ЦХХББХЭ} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$$

Эх үүсвэр:

Ажиллах хүчний судалгаа

Ангилал, код:

ISCO-08 - ажил, мэргэжлийн ангилал;

ISIC-4 - эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 8 дугаар сарын 15

Нийгмийн статистикийн газрын
даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Нийгмийн статистикийн газар
Өрхөд суурилсан судалгааны хэлтэс
Статистикч Н.Болорчимэг
Утас : (976-51)-265543

